

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА, БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилгын тухай хуулийн 42.1-д заасан чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд барилга байгууламж, барилгын үйл ажиллагаанд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр тавих шаардлагыг тогтоож, бүртгэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ журмыг мөрдлөг болгоно.

1.3. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд нь захиалагчтай гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд гэрээнд зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, хөтөлбөр, төлөвлөгөө, мэргэжлийн хариуцлагын даатгал зэргийг тусгаж хэрэгжүүлнэ.

1.4. Барилга байгууламж, барилгын үйл ажиллагаанд энэ журмын дагуу бүртгүүлсэн зөвлөх үйлчилгээг үзүүлэх иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх бөгөөд Барилгын тухай хуульд заасан бүх ангиллын барилга байгууламж, барилгын үйл ажиллагаанд “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг мөрдлөг болгоно.

1.5. Энэ журмын 1 дүгээр хавсралтад дурдсанаар зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь хэд хэдэн ажлын цар хүрээгээр тухайн ажлыг гүйцэтгэж болно.

1.6. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь Барилгын тухай хуулийн 8.2, 8.3-т заасны дагуу мэргэжлийн хариуцлагын болон холбогдох бусад үйл ажиллагааны даатгалд даатгуулсан байна.

1.7. Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль, Барилгын тухай хуулиар зохицуулна.

1.8. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь орон нутгийн өмчит болон оролцоотой хуулийн этгээд байхыг хориглоно.

Хоёр. Зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

2.1. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаандаа Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, норм, нормативын баримт бичгийг мөрдөх, барилга байгууламж нь байгаль орчинд ээлтэй, ус, эрчим хүч, эдийн засгийн хэмнэлттэй ногоон барилгын шаардлагад нийцсэн байх зорилтын хүрээнд дор дурдсан зарчмыг баримтална:

2.1.1. мэргэжлийн ёс зүйг чанд баримтлах;

2.1.2. хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах;

2.1.3. ашиг сонирхлоос ангид байх, бусдын нөлөөнд үл автах;

2.1.4. зөвлөх үйлчилгээ үзүүлж буй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;

2.1.5. бусдын нэр хүнд, бизнесийн үйл ажиллагаанд санаатай болон санаандгүй байдлаар хохирол учруулахгүй байх.

2.2. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь захиалагч, гүйцэтгэгчтэй нэгдмэл ашиг сонирхолтой бол зөвлөх үйлчилгээ үзүүлээс татгалзах үүрэгтэй.

Гурав. Барилгын тухай хуулийн 42.1-д заасан доор дурдсанаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэл, түүнд хамаарах ажлын хүрээ

3.1. Инженер-хайгуулын судалгааны чиглэлд хамаарах ажлын хүрээ:

3.1.1. барилга байгууламж барих талбайн инженер-геологи, геотехник, гидрогеологи, газар хөдлөлт, байгаль, ус, цаг уурын нөхцөл, газрын төлөв байдлыг тогтоох ажлын даалгавар боловсруулах;

3.1.2. инженер-геодези, инженер-геологи, геотехник, гидрогеологи, газар хөдлөлт, байгаль, ус, цаг уурын нөхцөлийг тогтоох судалгаа хийх, үнэлэх, зөвлөмж гаргах;

3.1.3. байгаль цаг уурын онцгой нөхцөлд барих барилгын үе шатны ажилд үзлэг хийх, зөвлөмж, дүгнэлт гаргах.

3.2. Хөрөнгө оруулалтын судалгааны чиглэлд хамаарах ажлын хүрээ:

3.2.1. төслийг хэрэгжүүлэх боломж, үндэслэлийг тогтоох, хөрөнгө оруулалтын урьдчилсан судалгаа, шинжилгээ хийх;

3.2.2. төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, түүнд үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.2.3. инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний төлөв байдал, түүгээр хангах боломжийг судлах, үнэлэх;

3.2.4. төслийн даалгавар, тендерийн баримт бичиг боловсруулах;

3.2.5. хөрөнгө оруулалт, санхүүгийн гэрээний төсөл боловсруулах;

3.2.6. төсөл хэрэгжүүлэх байгууллагад тавих нөхцөл, шаардлагын талаар санал боловсруулах.

3.3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, норм, нормативын баримт бичгийн боловсруулалтын түвшин тогтоох чиглэлд хамаарах ажлын хүрээ:

3.3.1. Барилгын тухай хуулийн 4.1.26, 4.1.27, 4.1.30, 4.1.43-т заасан зураг төслийн зургийн даалгавар, зураг төслийн боловсруулалтад үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.3.2. хот төлөвлөлт болон архитектур төлөвлөлт, Барилгын тухай хуулийн 4.1.26, 4.1.27, 4.1.30, 4.1.43-т заасан зураг төслийн даалгаврыг үнэлэх, дүгнэлт өгөх;

3.3.3. инженерийн тооцоо, техникийн шийдлийг үнэлэх;

3.3.4. зураг төслийн техникийн тодорхойлолт боловсруулах;

3.3.5. норм, нормативын баримт бичиг, зураг төсөл боловсруулах, тендерийн баримт бичгийг боловсруулах, түүнд үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.3.6. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах, үндэслэл, бусад улсын баримт бичгийн судалгаа гаргах;

3.3.7. Барилгын тухай хуулийн 5.1-д заасан норм, нормативын баримт бичгийн техникийн даалгавар болон боловсруулалтад үнэлэлт, дүгнэлт өгөх.

3.4. Барилгын материалын үйлдвэрлэлийн техник, эдийн засгийн үндэслэл, түүхий эд болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар, технологийн хяналт, зөвлөгөө, дүгнэлт гаргах, тоног төхөөрөмжийн угсралт, лабораторийн болон үйлдвэрлэлийн туршилт хийх, технологийн горим тогтоох чиглэлд хамаарах ажлын хүрээ:

3.4.1. барилгын материалын үйлдвэрийн технологийн тохируулга, зүгшрүүлэлт хийх, тоног төхөөрөмж угсрах, туршилт, тохируулга хийх зааварчилгаа боловсруулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн турших, сонгох;

3.4.2. эрдэс түүхий эд, материалын ашиглалт, боловсруулах технологи, бүтээгдэхүүн, түүхий эдийг үйлдвэрлэлд хэрэглэх үр ашгийг тооцох, үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.4.3. техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, үйлдвэрлэлийн технологийн заавар, бүтээгдэхүүний стандарт, бүтээгдэхүүнийг барилгад хэрэглэх аргачилсан заавар боловсруулах.

3.5. Барилгын ажлын механикжуулалт, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт хийх ажлын технологи, аргачлал тогтоох чиглэлд хамаарах ажлын хүрээ:

3.5.1. машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт, түүний эд ангийн үйлдвэрлэлийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, түүнд үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.5.2. инженерийн зураг төсөл боловсруулах, төслийн ажлын тоо хэмжээг тодорхойлох, өртгийн тооцоо хийлгэх;

3.5.3. машин механизм, тоног төхөөрөмжийн угсралт, ашиглалт, засвар, техникийн үйлчилгээ, оношилгоо, тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх.

3.6. Барилгын ажлын үе шатны ажилд хяналт тавих, дүгнэлт гаргах чиглэлд хамаарах ажлын хүрээ:

3.6.1. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь захиалагч байгууллагатай байгуулсан гэрээнд үндэслэн Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргийн дагуу "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 2, 3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.6.2. барилгын ажил гүйцэтгэх гэрээг хугацаанд нь чанартай, үр ашигтай гүйцэтгүүлэх, хяналт тавих;

3.6.3. барилга байгууламж, барилгын үйл ажиллагаанд өдөр тутмын үе шатны хяналт тавих;

3.6.4. барилгын үе шатны ажлын чанар, технологид үзлэг хийж, илэрсэн алдаа дутагдлыг нэн даруй засварлуулах, дүгнэлт гаргах;

3.6.5. барилгын ажил гүйцэтгэхэд тавигдах техникийн шаардлага боловсруулах;

3.6.6. технологийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, тохиргоо, зүгшрүүлэлтийн ажиллагаа үйлдвэрлэгчийн заавар, зураг төслийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих;

3.6.7. барилгын ажлын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих;

3.6.8. барилгын ажлын гэрээг хэрэгжүүлэх талаар төрийн болон орон нутгийн засаг захиргаа, холбогдох мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангуулах, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

3.6.9. барилга байгууламжийн гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулах, төслийн ажлын тоо хэмжээг тодорхойлох, өртгийн тооцоо хийх;

3.6.10. барилга байгууламжийн норм, норматив, стандартын шаардлага хангасан барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгөх;

3.6.11. барилга байгууламжийн технологийн алдаатай үйл ажиллагаанаас үүдэн чанарын баталгаат хугацаанд гарсан эвдрэл, гэмтлийг өөрийн хөрөнгөөр хариуцах;

3.6.12. барилга байгууламж, барилгын үйл ажиллагаатай холбоотой аливаа маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай судалгааг хийж, холбогдох дүгнэлтийг Захиалагчид гаргаж өгөх.

3.7. Барилга байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах чиглэлд хамаарах ажлын хүрээ:

3.7.1. барилгын ажил гүйцэтгэхэд тавигдах техникийн шаардлага боловсруулах;

3.7.2. барилгын байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.7.3. ашиглагдаж байгаа барилга байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах, паспортжуулах.

3.8. Төслийн удирдлага, зохион байгуулалт, технологийн түвшингийн чиглэлд хамаарах ажлын хүрээ:

3.8.1. төслийн баримт бичгийн боловсруулалт, түүний хэрэгжилтийг үе шат бүрээр хянах, үйл ажиллагааны горим дарааллыг тодорхойлох, мөрдүүлэх;

3.8.2. төслийн удирдлагын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, төслийн багийн бүтэц, зохион байгуулалт, ажлын чиг үүргийг тодорхойлсон удирдамжийг боловсруулж, хэрэгжүүлэх явцад зөвлөгөө өгөх;

3.8.3. төслийн ажил, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, технологийн процессын үйл ажиллагааны биелэлтийг хянах;

3.8.4. барилгын ажлын гүйцэтгэгчийн боловсруулсан аргачлал, технологийн карт, горимын схемийг хянах, техник технологийн сонголт, шийдлийн талаар санал боловсруулах;

3.8.5. төслийн техникийн шаардлагын баримт бичгийг нэгтгэн боловсруулах, ажлын цар хүрээ, ажлын багц, түүний задаргааг нарийвчлан гаргах;

3.8.6. ажилбаруудын горим дарааллыг тодорхойлох, тэдгээрийн ханган нийлүүлэлт, гүйцэтгэлийн хугацааг тооцоолон нэгдсэн хөтөлбөр гаргах, барилгын ажлын үе шат бүрийн зорилтот огноог тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих;

3.8.7. барилга байгууламжийн гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулах, төслийн ажлын тоо хэмжээг тодорхойлох, өртгийн тооцоо хийх;

3.8.8. чанарын удирдлага, чанарын хяналт болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын төлөвлөгөөг гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.8.9. төслийн харилцаа холбооны төлөвлөгөө гаргах, төслийн мэдээлэл тайлан, баримт бичгийг цаг хугацаанд нь боловсруулах, бүрдүүлэх, хүргүүлэх, дамжуулах болон хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах;

3.8.10. эрсдэлийг тодорхойлох, чанарын эрсдэл, үнийн эрсдэл, хугацааны нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бууруулах эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.8.11. сонгон шалгаруулалтын багцыг нэгтгэн боловсруулах, сонгон шалгаруулалтын төлөвлөгөө боловсруулах, зураг төсөл зохиогч, барилгын ажлын гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч нарыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, зөвлөмж боловсруулахад зөвлөгөө өгөх, тайлан зөвлөмж гаргах;

3.8.12. барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төслийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.8.13. барилгын ажлын зураг төсөл боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх, техникийн нөхцөл гаргуулах, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүсэлт гаргах, барилгын үйл ажиллагаанд хяналт тавих, хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулах, барилгын материал, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтэд тохирлын гэрчилгээтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэглэхэд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

3.8.14. төслийг эхлүүлэх, хаах, барилга байгууламжийг ашиглалтад оруулах, хүлээлгэж өгөх ажлыг удирдан зохион байгуулах, үе шатны болон хаалтын тайлан гаргах, дүгнэлт гаргана.

3.9. Барилгын тухай хуулийн 37.2-т заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд энэ журмын 3.6 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.10. Барилгын тухай хуулийн 42.1.9-д заасны дагуу зөвлөх үйлчилгээг иж бүрэн гүйцэтгэх ажлын хүрээнд энэ журмын 3.1-3.9 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага

4.1. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1. зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлд хамаарах энэ журмын 3 дахь хэсэгт заасан ажлын хүрээнд хамаарах чиглэлийн мэргэжилтэй байх;

4.1.2. Иргэд зөвлөх үйлчилгээг багаар гүйцэтгэж болох бөгөөд багийн ахлагчтай байна. Багийн ахлагч нь энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан шаардлагыг хангасан байх.

4.1.3. Барилгын тухай хуулийн 44.3.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй байх;

4.1.4. тухайн чиглэл, ажлын хүрээнд хамаарах ажил гүйцэтгэсэн байх.

4.2. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1. зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны чиглэлээр улсын бүртгэлд бүртгүүлсэн байх;

4.2.2. энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан орон тооны болон гэрээт мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байх;

4.2.3. зөвлөх үйлчилгээний хуулийн этгээдийн зөвлөхүүд нь энэ журмын 4.1-т заасан шаардлага хангасан байх.

Тав. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэл

5.1. Энэ журмын 4-т заасан шаардлагыг хангасан иргэн, хуулийн этгээд нь бүртгүүлсний үндсэн дээр зөвлөх үйлчилгээг эрхэлнэ.

5.2. Энэ журмын 3 дахь хэсэгт тусгагдаагүй шинэ техник, технологи, инноваци хэрэгжүүлэх ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийг бүртгүүлэх бол яамны дэргэдэх шинжлэх ухаан техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн 3, шийдвэрт үндэслэн бүртгэнэ.

5.3. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл нийтэд нээлттэй, цахим хэлбэртэй байх бөгөөд бүртгэлийг Барилгын тухай хуулийн 34.1.11-д заасны дагуу барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хөтөлж, мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцна.

5.4. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн нь дараах баримт бичгийг бүрдүүлж, бүртгүүлнэ:

5.4.1. зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүртгэлд бүртгүүлэх хүсэлт;

5.4.2. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэний нэр, регистрийн дугаар;

5.4.3. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэний боловсролын мэдээлэл /боловсролын мэдээллийн цахим системээс шалгана/;

5.4.4. шаардлагатай тохиолдолд бүтээлийн жагсаалт, танилцуулгыг хавсаргана.

5.5. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь дараах баримт бичгийг бүрдүүлж, бүртгүүлнэ:

5.5.1. зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүртгэлд бүртгүүлэх хүсэлт;

5.5.2. хуулийн этгээдийн мэдээлэл (Улсын бүртгэлийн гэрчилгээг мэдээллийн цахим системээс шалгана);

5.5.3. энэ журмын 2 дугаар хавсралтад заасан мэргэжилтнүүдийн мэргэжлийн үнэмлэх, диплом /боловсролын мэдээллийн цахим системээс шалгана/-ны болон мэргэшлийн зэргийн үнэмлэхийн хуулбар /мэдээллийг цахим системээр шалгана/-ын мэдээлэл;

5.5.4. Шаардлагатай бол боловсон хүчний мэдээллийг шалгахыг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлнэ;

5.5.5. Шаардлагатай бол зохих чиглэл, хүрээний дагуу гүйцэтгэсэн ажил, хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулга, хөрөнгө оруулагчийн тодорхойлолт, бусад нотлох баримт /ажил гүйцэтгэх гэрээ, улсын комиссын акт, гэрээ дүгнэсэн акт гэх мэт/.

5.6. Энэ журмын 4.3-т заасан байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч, дараах журмын дагуу бүртгэнэ:

5.6.1. энэ журамд заасан баримт бичгийн бүрдэл нь шаардлага хангасан эсэхийг хянах;

5.6.2. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн мэргэжилтний холбогдох мэдээллийг барилгын салбарын ажилтны нэгдсэн бүртгэлтэй тулгаж хянах;

5.6.3. шаардлагатай бол зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүтээл, гүйцэтгэсэн ажлыг тухайн батлагдсан бүтээл болон ашиглалтад орсон барилга байгууламжийн гэрээ, улсын комиссын актыг холбогдох системээс шалгана.

5.7. Иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлт энэ журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг ажлын 7 хоногт багтаан хянаж, шаардлага хангасан тохиолдолд нэгдсэн бүртгэлд бүртгэж, бүртгэгдсэн талаарх мэдээллийг цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

5.8. Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт шаардлага хангаагүй тохиолдолд үндэслэл, тайлбарын хамтаар татгалзсан тухай хариуг хүсэлт гаргагчид түүний цахим хаягаар мэдэгдэнэ.

5.9. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийг 5 жилийн хугацаагаар бүртгэж, мөн хугацаагаар хүсэлт ирүүлсний үндсэн дээр сунгана.

5.10. Энэ журмын 3.9-д заасан зөвлөх үйлчилгээг Барилгын тухай хуулийн 10.1.4, 10.1.5-т заасан ангиллын тухайн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх гэрээний хугацаагаар бүртгэнэ.

5.11. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь орон тооны болон гэрээт мэргэжилтнүүд өөрчлөгдсөн талаарх мэдээллийг тухай бүр энэ журмын 5.3-т заасан байгууллагад гаргаж, нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй.

5.12. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийг дараах тохиолдолд бүртгэлээс хасна:

5.12.1. иргэн, хуулийн этгээд өөрөө хүсэлт гаргасан;

5.12.2. зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүртгэлийн хугацаа дуусгавар болсон бөгөөд сунгуулах хүсэлт гаргаагүй;

5.12.3. хуурамч баримт бичиг бүрдүүлж бүртгүүлсэн нь барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

5.12.4. үйл ажиллагаандаа Барилгын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн нь хөрөнгө оруулагч, захиалагчид хохирол учирсан болохыг барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

5.12.5. орон тооны болон гэрээт мэргэжилтнүүд нь ажлаас чөлөөлөгдөж, гэрээний хугацаа дуусан дахин сунгалт хийгээгүй болон энэ журмын шаардлагад нийцсэн бүрэлдэхүүнгүй болсон;

5.12.6. хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан;

5.12.7. тухайн зөвлөх нь өөрийн хүсэлтээр зөвлөх үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зургаа. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн сан

6.1. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлийн мэдээллийн сан дараах мэдээллийг агуулна:

6.1.1. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэр;

6.1.2. бүртгэгдсэн огноо;

6.1.3. зөвлөх үйлчилгээний чиглэл, ажлын хүрээ;

6.1.4. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэний хувьд гадаад хэлний мэдлэг;

6.1.5. мэргэшлийн зэрэг;

6.1.6. ажлын туршлага /энэ журмын 5.1.10-т зааснаар/;

6.1.7. ажилласан жил;

6.1.8. бүтээлийн жагсаалт /баталсан тушаал, шийдвэр/;

6.1.9. зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн хувьд багийн ахлагч болон мэргэжилтнүүдийн мэдээлэл энэ журмын 5.1.1-ээс 5.1.8-д дурсан агуулгаар байршуулна. /ажилтан тус бүрээр/;

6.1.10. зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн гүйцэтгэсэн ажлын жагсаалт, түүнд холбогдох мэдээлэл;

6.1.11. зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, албан ёсны эрхтэй программ хангамжийн талаарх мэдээлэл;

6.1.12. Тухайн зөвлөхийн гүйцэтгэсэн ажлын мэдээллийг хөрөнгө оруулагч, захиалагчийн ирүүлсэн тодорхойлолтод үндэслэн байршуулна;

6.1.13. холбоо барих мэдээлэл.

6.2. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан нь хөрөнгө оруулагч, захиалагч цахимаар хандаж, шүүлт хийх, өөрийн гүйцэтгүүлэх ажилд шаардлагатай зөвлөхийн талаарх мэдээллийг үзэх, сонгох боломжтой, нийтэд хүртээмжтэй байна.

6.3. Мэдээллийн сангийн цахим системд хандах хэрэглэгч нь дараах төрөлтэй байна. Үүнд:

6.3.1. админ;

6.3.2. үндсэн хэрэглэгч;

6.3.3. тусгай хэрэглэгч;

6.4.4. энгийн хэрэглэгч.

6.4. Админы эрхийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар цахим бодлого, мэдээллийн систем хариуцсан албан тушаалтанд олгоно.

6.5. Админ нь мэдээллийн сангийн цахим системд хандах үндсэн болон тусгай хэрэглэгчийн эрхийг нээх, цуцлах, өөрчлөх, сэргээх хүсэлтийг уг системээр дамжуулан хүлээн авч, олгоно.

6.6. Админ нь үндсэн болон тусгай хэрэглэгчийн эрхийг тухайн албан тушаалд томилогдсон болон чөлөөлөгдсөн тушаал, нууцын баталгааг үндэслэн яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр олгож, өөрчилж, цуцална.

6.7. Мэдээллийн сан нь барилгын салбарын мэдээллийн нэгдсэн сан болон бусад холбогдох мэдээллийн сантай холбогдох, мэдээлэл солилцох боломжтой байна.

6.8. Мэдээллийн санд тухайн төсөл, арга хэмжээнд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэсэн ажлын талаар санал, хүсэлттэй холбоотой мэдээллийг хөрөнгө оруулагч, захиалагчийн тодорхойлолтыг үндэслэн байршуулна.

Долоо. Бусад

7.1. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой санал, гомдлыг цахим бүртгэлийн системд байршуулж, хуульд заасны дагуу шийдвэрлэх, бүртгэлийн талаар цахим хуудсаар болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад тайлагнах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

7.2. Захиалагч нь барилга байгууламж, барилгын үйл ажиллагаанд хууль, тогтоомж, норм, норматив, стандартыг зөрчих, илт хууль бус шаардлагыг биелүүлэхийг шаардах, дарамтлах, үйл ажиллагааг хясан боогдуулах зэрэг үйлдлийг зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид тавихыг хориглох бөгөөд зөвлөх үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

7.3. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь тухай ажлын гэрээний нөхцөлийг ноцтой зөрчсөн, барилга байгууламж, барилгын үйл ажиллагааг чанаргүй гүйцэтгэснийг барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын тогтоосноор гуравдагч этгээд /хөрөнгө оруулагч/-д учруулсан хохирлыг Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээнээс үл хамааран төлж барагдуулна.

7.4. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь барилга байгууламжийг норм, норматив, стандарт болон тохирлын гэрчилгээгүй барилгын материал ашигласан зэрэг мэргэжлийн ёс зүйн алдаа гаргасныг барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын тогтоосон бол мэргэшлийн зэргийг таван жилээр цуцалж, бүртгэлээс хасаж, Зөрчлийн тухай хуулийн хариуцлага хүлээнэ.

7.5. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч болон түүний мэргэжилтнүүд санаатай болон санамсаргүй үйл ажиллагааны улмаас гаргасан алдаа, учруулсан хохиролыг барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллага тогтоосон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, бүртгэлээс хасна.

7.6. Энэ журмын 7.3, 7.4-т заасныг дахин гаргасан бол зөвлөх үйлчилгээний бүртгэлд бүртгэхээс татгалзана.

7.7. Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд болон албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн
этгээдэд тавих шаардлага, бүртгэх журмын
1 дүгээр хавсралт

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ТҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА

Зөвлөх үйлчилгээний чиглэл	Зөвлөх үйлчилгээний чиглэлд хамаарах ажлын хүрээ	Шаардлагатай мэргэжилтэн	Багийн ахлагчид тавигдах шаардлага	Мэргэжилтэнд тавигдах шаардлага
1	3.1.1 3.1.2 3.1.3	-Инженер-геологийн инженер -Гидро-геологи инженер -Геодезийн инженер	-Тухайн ажлын чиглэлээр 15 буюу түүнээс дээш жил ажилласан;	-Тухайн ажлын чиглэлээр 10 буюу түүнээс дээш жил ажилласан;
2	3.2.1 3.2.2 3.2.3 3.2.4 3.2.5 3.2.6	-Барилга хөрөнгө оруулалтын төслийн менежментийн мэргэжилтэн -Тухайн салбар, үйл ажиллагааны чиглэлийн эдийн засагч -Тухайн салбар, үйл ажиллагааны чиглэлийн инженер -Үнэлгээ, төсөв, тооцоо, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн	-Зөвлөх инженер, тэргүүлэх төсөвчин- ээрэгтэй байх;	-мэргэшсэн болон түүнээс дээш инженерийн ээрэгтэй байх;
3*	3.3.1 3.3.2 3.3.3 3.3.4 3.3.5 3.3.6 3.3.7	-Архитектор -Барилгын инженер -Үйлдвэрлэлийн технологич -Механик инженер -Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер -Ус хангамж, ариутгах татуургын инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Холбоо, дохиолол, мэдээллийн сүлжээний инженер	-Тухайн чиглэлээр ажил гүйцэтгэсэн байх.	-Тухайн чиглэлээр ажил гүйцэтгэсэн байх.

		-Инженер-геологийн инженер -Геодезийн инженер -Барилгын эдийн засагч-төсөвчин		
4	3.4.1 3.4.2 3.4.3	-Барилгын материалын үйлдвэрийн технологич инженер -Барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн механик инженер -Тухайн үйл ажиллагааны чиглэлийн эдийн засагч		
5	3.5.1 3.5.2 3.5.3	-Механик инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Тухайн салбар, үйл ажиллагааны чиглэлийн эдийн засагч		
6*	3.6.1 3.6.2 3.6.3 3.6.4 3.6.5 3.6.6 3.6.7 3.6.8 3.6.9 3.6.10 3.6.11 3.6.12	-Архитектор -Барилгын инженер -Механик инженер -Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер -Ус хангамж, ариутгах татуургын инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Холбоо, дохиолол, мэдээллийн сүлжээний инженер -Барилгын эдийн засагч-төсөвчин -Барилгын материалын технологич инженер -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан		
7	3.7.1 3.7.2 3.7.3	-Барилгын инженер -Механик инженер -Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер -Ус хангамж, ариутгах татуургын инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Холбоо, дохиолол, мэдээллийн сүлжээний инженер -Барилгын материалын технологич инженер		

8	3.8.1 3.8.2 3.8.3 3.8.4 3.8.5 3.8.6 3.8.7 3.8.8 3.8.9 3.8.10 3.8.11 3.8.12 3.8.13 3.8.14	-Архитектор -Барилгын инженер -Механик инженер -Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер -Ус хангамж, ариутгах татуургын инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Холбоо, дохиолол, мэдээллийн сүлжээний инженер -Барилгын эдийн засагч-төсөвчин -Барилгын материалын технологич инженер -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан		
9	3.9	-Архитектор -Барилгын инженер -Механик инженер -Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер -Ус хангамж, ариутгах татуургын инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Холбоо, дохиолол, мэдээллийн сүлжээний инженер -Барилгын эдийн засагч-төсөвчин -Барилгын материалын технологич инженер -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан		
10	3.10	Зөвлөх үйлчилгээний 1-8 дугаарт хамаарах шаардлагатай бүх мэргэжилтэн		

Тайлбар:

-Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь зөвлөх үйлчилгээний чиглэл болон ажлын хүрээгээр бүртгүүлэх бөгөөд холбогдох чиглэлд хамаарах мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байна.

-“*”-той чиглэлд шаардлагатай мэргэжилтнүүдийн 50%- аас доошгүй нь үндсэн ажилтан байна.

---o0o---

ТӨСӨЛ